

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Байшинт

2023.01.03

Энэхүү гэрээг нэг талаас Увс аймаг(нийслэл) Бөхмөрөн сум (дүүрэг)-ын Засаг дарга Б.Сүхтулга (цаашид "Засаг дарга" гэх), нэгтэй талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Жанат ХХК (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 01-р сарын 03-ны өдөр Увс аймаг (нийслэл) Бөхмөрөн сум (дүүрэг)-нд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Увс аймаг Бөхмөрөн сум (дүүрэг)-ын Хар алтат багийн нутагт Ашигт малтмалыг тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах :

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах :

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилтэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх:

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах :

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих :

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх .

2.1.7. уурхайн үйл ажиллагаа явуулахад сум орон нутгийн засаг захиргааны зүгээс холбоотой болсон ажил, бичиг баримтуудыг цаг харгалзахгүйгээр тухай бүр нь саадгүй үйлчлэх.

* Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах :

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах :

3.1.4. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх:

3.1.5. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг) –ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх :

3.1.6. бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох :

3.1.7. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах:

3.1.8. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.9. Иргэдэд үнэгүй олгох 400 тонн нүүрсийг 2023 оны 10-р сарын 01-аас 2023 оны 12-р сарын 20-ны хооронд ачааны машинаар олгох. Тухайн хугацаанд амжиж авахгүй бол компани хариуцлага хүлээхгүй.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнэ.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

Тав. Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Зургаа . Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи , уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.


8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,
УВС АЙМАГ, БӨХМӨРӨН СҮМЫН
ЗАСАГ ДАРГА
(Б. СҮХТУЛГА)

АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,
ЖАНАТ ХХК-НЫ ЗАХИРАЛ
(М. ТИЛЕУБЕРДИ)


Жанат ХХК-тай байгуулсан гэрээний хавралт

Хамтын ажиллагааны гэрээнд хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх төсөл,
хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх талууд	Санхүүжүүлэгч тал	Төсөв/ зардал	Хэрэжих цаг, хугацаа
1	Хар-алтат багийн хуучин угаалгын ванн засварлах	ЗДТГ	Жанат ХХК	10.0 сая	5-6 сар
2	Засаг даргын Таймын газарт дэмжлэг	ЗДТГ	Жанат ХХК	10.0 сая	1-2 сар
3	Иргэдэд хөнгөлөлттэй нүүрс олгох	ЗДТГ	Жанат ХХК	13.5 сая	10.20-11.15
4	Нэг зам төсөл	ЗДТГ	Жанат ХХК	6.0 сая	8-9 сар
5	ЗДТГ-ын архивын байр засварлах	ЗДТГ	Жанат ХХК	3.5 сая	1-2 сар
6	Гэрээт ажилтны цапин	ЗДТГ	Жанат ХХК	13.2 сая	1-12 сар
Нийт төсөв					56.2 сая төгрөг